



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/48

Хэрлэн сум

Галшар сумын Онцгой комисст
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зудын үнэлгээгээр “Төмөр зуд”-ын түвшинд хүрсэн Галшар суманд өвс, тэжээл хүргэх, зам, даваа нээх үйл ажиллагаанд зориулж 3,526,000 (гурван сая таван зуун хорин зургаан мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024
оны 02 дүгээр сарын 01-ны
... дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Сумын нэр	Маршрут зай	Машины марк, шатахууны зарцуулалт	Шаардагдах шатахуун төрөл, хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Галшар сум /хивэг/	Чингис-Бэрх-Галшар /ирж буцах/ 450км	Урал 100/210 цас хаглаж хүнд араагаар явах	Ай-92 950л	2,520 төг	2,394,000 төг
				Масло-5л	16,000 төг	80,000 төг
				Тосол-15л	7,000 төг	105,000 төг
2	Галшар сум /өвс/	Чингис-Галшар /ирж буцах/ 320км	Шаланз 100/80	Д/түлш 256л	3,700 төг	947,000 төг
Нийт		770км		-		3,526,000 төг